



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/590

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.12 дахь хэсэг, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 68 дугаар тушаал, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1. Аймгийн хэмжээнд Зудын эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Ажлын хэсгийн дарга: Л.Бямбасүрэн- Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа,
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Ч.Цолмонзаяа- Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, дэслэгч,

Ажлын хэсгийн гишүүд:

Аймгийн гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн гишүүд

А.Баянхангай- Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлтгэл бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад,

Ч.Цогжаргал - Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Мэдээлэл үйлчилгээний албаны дарга,

Н.Бэлэгдэмбэрэл- Хүнс хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

М.Даваамөнх- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

2. Үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга, дэд хурандаа Л.Бямбасүрэнд даалгасугай.

3. Үнэлгээ хийх ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлага зохион байгуулалт, холбогдох мэдээллээр хангахыг аймгийн Онцгой комиссын гишүүд, гамшгаас хамгаалах алба, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн засаг даргын орлогч М.Хуягбаатар, Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа С.Ганболд нарт үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ